



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 12/11

Эрдэнэт


Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Холбогдох хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны
11 дүгээр сарын 22-ны өдрийн Ээлжит XII хуралдааны
1211 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
- Гишүүд:
- Аймгийн Засаг дарга
 - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлийн хорооны дарга
 - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
 - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
 - Хотын захирагчийн албаны дарга
 - Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
 - Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
 - Аймгийн Онцгой байдлын газрын дарга
 - Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
 - Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
 - “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ерөнхий менежер
 - Аймгийн Улаан загалмайн хорооны дарга
- Нарийн бичгийн дарга: - Аймгийн Онцгой байдлын газрын орлогч дарга

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны
11 дүгээр сарын 22-ны өдрийн Ээлжит XII хуралдааны
12/11 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл (цаашид "Орон нутгийн зөвлөл" гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Орон нутгийн зөвлөл нь үйл ажиллагаандаа Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгоно.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Орон нутгийн зөвлөлийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүлнэ.

2.2. Орон нутгийн зөвлөлийн ажлын албыг Онцгой байдлын газрын дарга удирдаж, ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг тус байгууллагын урьдчилан сэргийлэх хяналтын тасаг эрхэлнэ.

2.3. Газар хөдлөлтийн гамшгийн урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах байнгын ажиллагаатай зөвлөл нь Орон нутгийн зөвлөлийн дэд зөвлөл байна. Тус зөвлөлийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, үйл ажиллагааг аймгийн Засаг даргын орлогч дарга эрхлэн явуулна.

2.4. Аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, албад нь чиг үүргийн хүрээнд Орон нутгийн зөвлөлтэй үйл ажиллагаагаа уялдуулж ажиллана.

ГУРАВ. ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

3.1. Орон нутгийн зөвлөл нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.2. Аймгийн Онцгой комиссоос оруулсан гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хойшлуулшгүй сэргээн босгох төсвийг хэлэлцэж, батлах, гүйцэтгэлд хяналт тавина.

3.3. Орон нутгийн зөвлөлийн гишүүн нь дараах эрхтэй.

3.3.1. Шаардлагатай тохиолдолд Орон нутгийн зөвлөлийн ээлжит бус хуралдааныг хуралдуулах санал гаргах;

3.3.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд болон орон нутгийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд шаардагдах судалгаа, мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

3.3.3.Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хариуцсан салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ, салбар хоорондын зохицуулалтыг хангах асуудлыг Орон нутгийн зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх.

3.4.Орон нутгийн зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй.

3.4.1.Гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлсэн ажлаа Орон нутгийн зөвлөлийн хурал, холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах;

3.4.2.Гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой бодлогын зөвлөмж боловсруулах, бусад гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж салбар дундын зохицуулалтыг хангах;

3.4.3.Орон нутгийн зөвлөлөөс гарсан шийдвэр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, холбогдох зардлыг тухайн жилийн төсөвтөө тусгах.

ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН

4.1.Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг Орон нутгийн зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.

4.2.Хуралдааны дэгийг Орон нутгийн зөвлөл батална. Орон нутгийн зөвлөлийн хуралдааны шийдвэр нь хуралдааны тэмдэглэл байна.

4.3.Орон нутгийн зөвлөлийн ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

4.4.Ээлжит хуралдааны товыг хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хуралдааны материалыг тараасан байна.

4.5.Орон нутгийн хуралдааныг нийт гишүүдийн олонх оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхын саналаар, санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргана.

4.6.Орон нутгийн зөвлөлийн даргын шийдвэрээр орон нутгийн зөвлөлийн хуралдаанд холбогдох эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллөөс оролцуулж болно.

ТАВ. ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ

5.1.Орон нутгийн зөвлөлийн ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.1.1.Орон нутгийн зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, хуралдааныг зохион байгуулах;

5.1.2.Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад гишүүдээс гадна бусад холбогдох талуудыг татан оролцуулах, хяналт тавих;

5.1.3.Орон нутгийн зөвлөлд ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, орон нутгийн зөвлөлийн хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх;

5.1.4.Орон нутгийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж тайлагнах;

5.1.5.Орон нутгийн зөвлөлөөс зохион байгуулж байгаа ажил, түүний явц, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, сурталчлах;

5.1.6.Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичиг, мэдээ мэдээлэл, судалгааг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдээс гаргуулан авах;

5.1.7.Үндэсний зөвлөлд үйл ажиллагаагаа тайлагнах.

ЗУРГАА. БУСАД

6.1.Орон нутгийн зөвлөл нь холбогдох журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

6.2.Орон нутгийн зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааны зардлыг Онцгой байдлын газрын төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.